

“MNP75” үйлчилгээний ерөнхий нөхцөл

Энэхүү үйлчилгээний нөхцөлд “MNP75” үйлчилгээг ашиглахад тавигдах шаардлагууд болон хэрэглэгчийн хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах, боловсруулах, хадгалахтай холбоотой хууль зүйн заалтууд тусгагдсан байгаа тул таныг үйлчилгээний нөхцөлтэй сайтар танилцаж, зөвшөөрөх эсэхээ шийдэхийг зөвлөж байна.

Гишүүнчлэл: Үйлчилгээг ашиглахын тулд та 18 насанд хүрсэн байх бөгөөд таны бүртгүүлэх үедээ оруулсан мэдээлэл үнэн зөв байх шаардлагатай.

Хэрэглэгчийн бүртгэл:

- Үйлчилгээг авахын тулд та MNP75 үйлчилгээний дугаар худалдан авах шаардлагатай ба дугаараа авах явцад өөрийн регистрийн дугаар, бүртгэлтэй имейл болон утасны дугаар зэрэг мэдээллүүдийг оруулж бүртгэлээ хийлгэнэ. Эдгээр мэдээлэл дээр үндэслэн таны худалдан авах дугаарыг үүсгэх тул мэдээллүүдээ үнэн зөв оруулах шаардлагатай.
- Салбараар дугаараа худалдан авч бүртгэл хийлгэсэн тохиолдолд аппликейшн рүү нэвтрэх нууц үгийг бүртгэлтэй и-мейл болон дугаар руу нь илгээх боломжтой.
- Онлайнаар дугаар авч бүртгэлээ хийлгэсэн тохиолдолд аппликейшн руу нэвтрэх нууц үгийг зөвхөн хэрэглэгч таны бүртгэлтэй и-мейл рүү илгээнэ. Онлайнаар зөвхөн урьдчилсан төлбөрт дугаар худалдан авах боломжтой. Дараа төлбөрт дугаарыг зөвхөн үйлчилгээний салбар дээр очиж гэрээ байгуулан авах боломжтой.
- Үйлчилгээнд бүртгүүлсэн хэрэглэгч та өөрийн бүртгэлийн мэдээллээ лавлах болон салбарт хандан өөрчлүүлэх боломжтой. Аппликейшн дээрээс бүртгэлийн мэдээллээ өөрчлөх боломжгүй бөгөөд зөвхөн нууц үгээ сэргээх, солих боломжтойг анхаарна уу.

Үйлчилгээний нөхцөл :

- Энэхүү үйлчилгээг ашиглахын тулд та үйлчилгээний аппликейшн татах шаардлагатай.
- Тус үйлчилгээний аппликейшнаар дамжуулан дуудлага хийх, хүлээж авах, зурвас бичих болон хүлээж авах боломжтой.
- Үйлчилгээг Урьдчилсан төлбөрт болон дараа төлбөрт гэсэн 2 төрлийн багцаас сонгох боломжтой.
- Урьдчилсан төлбөрт үйлчилгээний дугаарыг онлайнаар буюу веб хуудсаар болон үйлчилгээний салбараас авах боломжтой.
- Дараа төлбөрт үйлчилгээний дугаарыг үйлчилгээний салбараас шууд авах боломжтой онлайнаар буюу вебээр дамжуулан дугаар худалдан авалт хийж буй тохиолдолд зөвхөн хадгалуулах боломжтой ба үйлчилгээний салбар дээр очиж гэрээ байгуулан дугаараа авахыг анхаарна уу.
- Мобинет ХХК нь аппликейшн болон үйлчилгээг сайжруулах, засвар үйлчилгээг хэрэглэгч танд мэдэгдэлгүйгээр хийж болно. Энэхүү засвар үйлчилгээ болон

сайжруулалтыг хийхэд аппликейшн болон үйлчилгээний үйл ажиллагаанд тасалдал үүсэх нөхцөлд хэрэглэгч танд урьдчилан мэдэгдэнэ.

- Хэрэглэгч та үйлчилгээний талаар санал, гомдол гаргах бол 2288, 75952288 үйлчилгээний лавлах шугамууд болон customercare@mobinet.mn мейл хаяг руу хандан шийдвэрлүүлэх эрхтэй.

Төлбөр тооцоо:

Хэрэглэгч үйлчилгээг авах болон хэрэглэхтэй холбоотой аливаа төлбөр тооцоог Monpay, Qpay гэх мэт “Мобинет ХХК”-иас хүлээн зөвшөөрөгдсөн бүх төрлийн төлбөрийн хэрэгслийг ашиглан төлөх боломжтой.

Дараа төлбөрт хэрэглэгч төлбөрөө дараа сарын 20-ны өдрийн дотор төлөх үүрэгтэй. Төлөөгүй тохиолдолд орох, гарах яриа болон мессэжний эрх хаагдна.

Хэрэглэгчийн хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах, боловсруулах, хадгалах

- Үйлчилгээ үзүүлэгч болон түүний охин, хараат компаниуд нь хэрэглэгчдэд бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэхийн тулд хүний хувийн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглахад Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай”, “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн дараах нөхцөлийг баримтлан, хэрэгжүүлнэ. Үүнд:
- Үйлчилгээ үзүүлэгч нь холбогдох хууль, тогтоомж, энэ нөхцөлд заасны дагуу хэрэглэгчийг таних, баталгаажуулах, бүртгэлжүүлэх, мөн бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулах, хэрэглэгчийн санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, дүн шинжилгээ хийх, төлбөр цуглуулах, урамшуулал сурталчилгааны мэдээлэл, мэдэгдэл хүргэх зорилгоор хүний хувийн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглана.
- Үйлчилгээ үзүүлэгч нь бүтээгдэхүүн үйлчилгээнд сайжруулалт хийх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгох зорилгын хүрээнд хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний хувийн мэдээллийг гуравдагч этгээдэд гэрээний үндсэн дээр дамжуулж болно. Үүнд: Урамшуулал, хөнгөлөлт гэх зэрэг маркетингийн үйл ажиллагаанд, гар утас төхөөрөмж засварлах, сүлжээний хүртээмж чанарыг сайжруулах, төлбөр цуглуулах, хууль тогтоомжоор хүлээсэн эрх үүргээ биелүүлэх зэргийг ойлгоно.
- Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээ болон үйлчилгээний нөхцлийн хүчин төгөлдөр хугацаанд, гэрээ буюу үйлчилгээ дуусгавар болсон эсхүл цуцлагдсанаас хойш гэрээний үүргийн биелэлтийг хангахтай холбоотойгоор үүсэх шаардах эрхийг хэрэгжүүлэх эсхүл хууль тогтоомжид заасан хугацаанд хүний хувийн мэдээллийг боловсруулж, ашиглана.
- Үйлчилгээ үзүүлэгч нь хүний хувийн мэдээллийг олон нийтэд ил болгохгүй бөгөөд цуглуулах, ашиглах, боловсруулах явцад санаатай болон санамсаргүйгээр алдах, устгах, өөрчлөх, хуулбарлах, бусад хууль бус ажиллагаанаас хамгаалах, мэдээлэл алдагдсан тохиолдолд мэдээллийн эзэнд хуульд заасны дагуу мэдэгдэх үүрэгтэй.
- Хэрэглэгч бичгээр хүсэлт гарган үйлчилгээ үзүүлэгчид олгосон өөрийн хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах, боловсруулах зөвшөөрлөө цуцлах эрхтэй.

- Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийг танин, баталгаажуулсны үндсэн дээр бүртгэл хийх шаардлагын дагуу хэрэглэгчийн баримт бичиг, Төрийн мэдээлэл солилцооны системд бүртгэгдсэн мэдээлэлд үндэслэн бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх тул хэрэглэгч нь энэхүү гэрээ, үйлчилгээний нөхцөлд гарын үсэг зурснаар тус системд бүртгэгдсэн өөрийн хувийн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглахыг зөвшөөрч байгаагаа баталгаажуулж байгаа болно.
- Энэхүү үйлчилгээний нөхцлийг зөвшөөрснөөр хэрэглэгч нь зөвхөн тухайн бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлж буй үйлчилгээ үзүүлэгчид энэхүү зөвшөөрлийг өгч байгаа болно.
- Энэхүү үйлчилгээний нөхцлийг зөвшөөрснөөр тухайн үйлчилгээ үзүүлж буй этгээдийн үйлчилгээг авах хүүхдийн тань мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах зөвшөөрлийг мөн өгч байгаа болно.
- Энэхүү үйлчилгээний нөхцөлийг уншиж танилцсанаар хэрэглэгч үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээг авах боломжтой болох бөгөөд нөхцөлтэй танилцаагүйгээс үүдэн гарах аливаа асуудлыг Үйлчилгээ үзүүлэгч хариуцахгүй.

Хэрэглэгчдэд мэдээлэл хүргэх:

“MNP75” үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн 75-тай дугаар, гар утас, и-мэйл хаягт төлбөрийн мэдээлэл, мэдэгдэл, шинэ урамшуулал болон “MNP75” үйлчилгээтэй холбоотой мэдээллийг хүргэх эрхтэй байна.

Үйлчилгээний лавлах:

Та “MNP75” үйлчилгээний заавар болон бусад дэлгэрэнгүй мэдээллийг www.mobinet.mn, “Mobinet” сошиал хуудас болон 2288 Хэрэглэгчийн мэдээлэл үйлчилгээний нэгдсэн төвөөс авах боломжтой.